



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 8/98

Мандалговь

“Тивинпи Сервис” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Аймгийн Засаг даргын 2022 оны 02 сарын 12-ны өдрийн А/42 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих их засварын хөдлөх хөрөнгийн их засвар үйлчилгээний батлагдсан зардлаас “0001ДУА дугаартай ланд 200 маркын ажлын албаны автомашины засвар” шинэчлэлийн ажлыг “Тивинпи Сервис” ХХК-тай 3,992,450 (гурван сая есөн зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун тавь) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд “0001ДУА дугаартай ланд 200 маркын ажлын албаны автомашины засвар” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тивинпи Сервис” ХХК-ны гүйцэтгэх захирал (Т.Энхтөр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Үйлчилгээний албаны дарга (М.Батсайхан) гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *V. Alt* Л.ДОРЖБАТ

1820150225